



ҮАГ
Үндэсний аудитын газар

**Улсын гаалийн ерөнхий газрын
зарим үйл ажиллагаа**



**Татвараас чөлөөлөгдсөн
импортын барааны ашиглалтад
тавих дотоодын хяналтыг
сайжруулах шаардлагатай байна**

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны саналаар хийсэн аудитын тайлан

Улаанбаатар 2007 оны 6 дугаар сар

ҮАГ -1/2007/03-ЭА

Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Агуулга	1
ҮАГ-ын нэгдүгээр газар	Товчилсон үгсийн жагсаалт	3
<i>Газрын захирал</i> <i>Д.Ганбилэг</i>	Бүлэг 1 Ерөнхий зүйл	
<i>Аудитын менежер</i> <i>Ж.Батсайхан</i>	<ul style="list-style-type: none">• Аудит хийсэн үндэслэл	4
<i>Ахлах аудитор</i> <i>Л.Одгэрэл</i>	<ul style="list-style-type: none">• Аудитын зорилт, хамарсан хүрээ	4
<i>Аудитор</i> <i>А.Сүхбаатар</i> <i>Д.Гандолгор</i>	<ul style="list-style-type: none">• Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа	5
<i>Шинжээч</i> <i>Ц.Эрдэнэчулуун</i>	<ul style="list-style-type: none">• УГЕГ-ын талаархи товч мэдээлэл	5
2006 оны 12 дугаар сар	Бүлэг 2 Татвараас чөлөөлөгдсөн импортын барааны хэмжээ буурсан боловч түүний ашиглалтад тавих хяналт хангалтгүй байна	
Тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:	<ul style="list-style-type: none">• Татвараас чөлөөлөгдсөн импортын барааны хэмжээ буурсан байна	8
www.mnao.pmis.gov.mn	<ul style="list-style-type: none">• Гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөгдсөн барааны ашиглалтад тавих хяналт хангалтгүй байна	10
<i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	Бүлэг 3 Зарим худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилт хангалтгүй байна	
ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар</i> <i>Засгийн газрын</i> <i>4 дүгээр байр,</i> <i>Бага тойруу-6,</i> <i>Улаанбаатар-46</i> <i>Монгол Улс</i>	<ul style="list-style-type: none">• 2006 оны худалдан авах үйл ажиллагааг төлөвлөөгүй байна	11
	<ul style="list-style-type: none">• 2006 оны зарим худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилт хангалтгүй байна	12

Агуулга

	Аудитын дүгнэлт	14
	Холбогдох байгууллагын санал	15
	Аудитын зөвлөмж	17

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
СЭЗС	Санхүү, эдийн засгийн сайд
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам
УГЕГ	Улсын гаалийн ерөнхий газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ГТТХ	Гаалийн тарифын тухай хууль
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Бүлэг 1

Ерөнхий зүйл

1.1 Аудит хийсэн үндэслэл

Аудитыг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

УГЕГ-т хийсэн 2006 оны санхүүгийн аудитаар эрсдэлтэй байж болзошгүй гэж тогтоосон зарим асуудлыг шалгаж эрсдэлийг бууруулах, үр нөлөөг сайжруулах санал зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

1. Монгол Улсын хилээр импортлосон барааны гаалийн болон НӨАТ-ыг чөлөөлсөн байдал

2. УГЕГ-ын 2006 оны худалдан авах үйл ажиллагаа

Аудитаар УГЕГ-ын 2006 оны санхүүгийн болон бусад холбогдох баримт материалыг шалгав.

Аудитад УГЕГ, Улаанбаатар хотын Гаалийн газар хамрагдсан ба Монгол Улсын хуулийн дагуу гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн импортын барааны үнийн дүнгийн 55,8 хувь, гаалийн байгууллагын 2006 оны худалдан авах үйл ажиллагаанд аудит хийв.

Их засвар хийсэн, шинээр барьж байгуулсан зарим объектуудтай газар дээр нь очиж танилцав. Үүнд:

- УГЕГ-ын барилгад хийсэн их засвар
- УГЕГ-ын өргөтгөлийн барилга
- Улаанбаатар хотын Гаалийн газрын барилгын засвар
- Горхи дахь Гаальчдын амралтын их засвар
- Гаалийн нохойн байрны их засвар, шинээр гаргасан гүний худаг
- Гаалийн төв лабораторийн барилгын засвар

Монгол Улсын ГТТХ, НӨАТТХ, бусад хуулийн дагуу 2006 онд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн 24 аж ахуйн нэгж, байгууллагын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан техник, тоног төхөөрөмж технологийн зориулалтаар ашиглаж байгаа эсэхийг шалгав.

1.3 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, эрсдэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав. Мөн байгууллагын удирдлагаас тодорхойлсон зорилго, зориулалт, мэргэжлийн стандарт, хэм хэмжээ, өнгөрсөн жилийн гүйцэтгэлийг ашиглав.

Аудитад

- Монгол Улсын 2006 оны төсвийн тухай хууль,
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Гаалийн тарифын тухай хууль,
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль,
- Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн Монгол Улсын хуулиуд
- Жагсаалт батлах тухай Засгийн газрын тогтоолууд
- “Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2006 оны 19 дүгээр тогтоол,
- СЭЗС (хуучин нэрээр)-ын 2001 оны 174 дүгээр тушаалаар баталсан “Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журам”,
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох бусад хууль тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.


Аудитыг Үндэсний аудитын газрын Нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэг, аудитын менежер Ж.Батсайхан нар удирдаж, Төсөв, санхүү, банк, өр зээлийн багийн ахлах аудитор Л.Одгэрэл, аудитор А.Сүхбаатар, Д.Гандолгор, шинжээч Ц.Эрдэнэчулуун нар 2007 оны 4 дүгээр сарын 23-наас 6 дугаар сарын 4-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

1.4 Улсын гаалийн ерөнхий газрын талаархи товч мэдээлэл

УГЕГ нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд улсын хэмжээнд гаалийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

УГЕГ-ын 9 хэлтэс, 6 алба харьяа Гааль эдийн засгийн дээд сургууль, Гаалийн төв лаборатори, Улаанбаатар болон орон нутгийн 9 газар, 8 хороонд нийт 1047 хүн ажиллаж байгаагийн 803 нь гаалийн улсын байцаагч байна.


Улсын гаалийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт



Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу БНХАУ-тай залгаа хилийн дагуу байнгын 5, түр 7, ОХУ-тай залгаа хилийн дагуу байнгын 12, түр 9, дамжин өнгөрөх 7, Олон Улсын нисэх буудалд 1, гүний 14, бүгд 53 цэгт гаалийн үйл ажиллагаа хийгдэж байна.

УГЕГ харъяа 20 салбарын санхүүгийн тайланг нэгтгэж, төсвийн санхүүжилтийг харъяалах орон нутгийн Төрийн сангийн дансаар дамжуулан шууд хуваарилан хийж байна.

Харъяа гаалийн газар, хороодын бүтэц.



2006 оны гаалийн орлогыг 2005 онтой харьцуулж үзвэл 23,9 хувь буюу 69,6 тэрбум төгрөгөөр, үүнээс импортын татварын орлого 67,0 тэрбум төгрөгөөр, экспортын татварын орлого 3,0 тэрбум төгрөгөөр тус тус өсч, бусад орлого 446,4 сая төгрөгөөр буурчээ.

Бүлэг 2

Татвараас чөлөөлөгдсөн барааны хэмжээ буурсан боловч түүний ашиглалтад тавих хяналт хангалтгүй байна

2.1 Татвараас чөлөөлөгдсөн импортын барааны хэмжээ буурсан байна

Нийт импорт үнийн дүнгээр 2006 онд 1671,8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 20,8 хувь буюу 288,1 тэрбум төгрөгөөр, үүнээс татвартай импорт 1295,5 тэрбум төгрөгт хүрч, 29,2 хувь буюу 292,5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татвараас чөлөөлөгдсөн импортын барааны хэмжээ өнгөрсөн оноос 1,1 хувь буюу 4,3 тэрбум төгрөгөөр, нийт импортын бараанд эзлэх хувь 5,0 /27,5-22,5/ пүнтээр буурсан байна.

ГТТХ-ийн 21 дүгээр зүйлийн дагуу 16 184,0 сая төгрөгийн гаалийн татвар, НӨАТТХ-ийн 9 дүгээр зүйлд заасны дагуу 56 591,1 сая төгрөгийн НӨАТ-ыг тус тус чөлөөлжээ.

Импортын барааг татвараас чөлөөлсөн байдлыг хуулийн заалтуудаар ангилан харуулбал:

/тэрбум-төгрөгөөр/

№	Татвараас чөлөөлсөн хэлбэр	Импортын барааны үнийн дүн	Чөлөөлсөн				Дүн
			Гаалийн татвар	НӨАТ	Албан	Онцгой албан татвар	
1	Засгийн газрын шугамаар буцалтгүй тусламжаар ирүүлсэн	44.6	2.2	7.0		0.1	9.3
2	Засгийн газрын бус шугамаар тусламжаар ирүүлсэн	3.2	0.1	0.6			0.6
3	Гадаад орнууд болон Олон улсын байгууллагуудаас олгож буй зээлийн санхүүжилтээр ирүүлсэн	19.2	0.9	3.0			3.9
4	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн болон газрын тосны салбарт хуулийн дагуу импортоор оруулсан	81.0	4.1	9.7			13.8
5	Монголросцветмет, Улаанбаатар төмөр замын импортоор оруулсан	88.5	4.4	14.6			19
6	Гадаадын захиалагчийн материалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргадаг үйлдвэрүүдийн захиалагчийн материалд	66.6	2.7	10.5			13.2
7	Татвараас чөлөөлөх бусад заалтын дагуу	73.2	1.8	11.3			13.1
	Дүн	376.3	16.2	56.6		0.1	73.0

Дээр дурдсан татварын чөлөөлөлтөөс Засгийн газрын шугамаар ирсэн буцалтгүй тусламжийн импортын барааны, Засгийн газрын гэрээгээр тохиролцсон импортын барааны, Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн импортын барааны, ГТТХ болон НӨАТТХ-ийн татвараас чөлөөлөх заалт, Монгол Улсын бусад хуулиудын дагуу чөлөөлөгдсөн барааны татварын чөлөөлөлтийг түүвэрлэн авч аудит хийсэн болно.

Засгийн газрын шугамаар ирүүлсэн тусламжийн 107 байгууллагын импортын 44,6 тэрбум төгрөгийн бараанд 9,3 тэрбум төгрөгийн, Засгийн газрын бус шугамаар ирүүлсэн тусламжийн 61 байгууллагын импортын 3,1 тэрбум төгрөгийн бараанд 0,6 тэрбум төгрөгийн гааль, НӨАТ-ын чөлөөлөлтийг Гаалийн тарифын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу үзүүлжээ.

ГТТХ-ийн 21 дүгээр зүйлийн 1.1, НӨАТТХ-ийн 9.2.10-т “тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, угсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизм. ...” гэж заасны дагуу 81039,6 сая төгрөгийн импортын бараанд ногдох 13726,3 сая төгрөгийн гааль болон НӨАТ-аас гадаадын хөрөнгө оруулалттай 66 аж ахуйн нэгжийг чөлөөлжээ.

Гадаадын хөрөнгө оруулалттай 8 аж ахуйн нэгжийг сонгон авч Гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн импортоор оруулсан техник, тоног төхөөрөмжийг гаалийн бүрдүүлэлтийн материалтай тулган шалгахад зарим компанийн улсын хилээр нэвтрүүлэх гаалийн мэдүүлэгт бүртгүүлсэн хаяг тодорхойгүй, өгсөн хаяг нь буруу, байршилдаа байхгүй, утасны дугаар алдаатай байлаа.

Оруулж ирсэн тоног төхөөрөмжөө ашиглаагүй, үндсэн хөрөнгийн данс бүртгэлд бүртгээгүй, үйл ажиллагаагаа эрхлээгүй тохиолдол байна.

Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх бусад хуулийн дагуу 2006 онд гааль болон НӨАТ-аас чөлөөлсөн импортын барааг хүснэгтээр харуулбал:

№	Барааны нэр төрөл	Гаалийн үнэ		Чөлөөлөгдсөн татвар (сая төгрөгөөр)
		мянган ам.доллар	сая төгрөг	
1	Компьютер, принтер, сканнер	29 903,1	35 196,0	5 279,4
2	Барилгын тоног төхөөрөмж	12 732,7	14 929,2	3 097,8
3	Хийн түлш, түүний тоног төхөөрөмж	2 809,0	3 310,6	686,9
4	Тарьц, суулгац, бөөрөнхий мод	351,5	415,1	86,1
5	Батлан хамгаалах, хүчний байгууллагын тусгай хэрэгслүүд	694,9	815,6	128,4
6	Үрийн улаан буудай	420,6	491,2	77,4

7	Донорын цус, цусан бүтээгдэхүүн, тэдгээрийг хадгалах сав	9,6	11,7	2,4
8	Тахир дутуу хүний хэрэгсэл	77,6	93,5	19,4
9	Гадаад орнуудад дахь дипломат байгууллагад ажилласан дипломатын автомашин	3 386,7	3 972,6	877,7
10	Нийтийн тээврийн автобус	173,8	203,1	42,1
11	Мянганы зам төслийн материал, тоног төхөөрөмж	1 606,0	1 894,0	393,0
12	Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд чөлөөлсөн	2 690,0	3 149,0	655,1
13	Баруун бүсийн цахилгаан эрчим хүч	1 621,4	1 922,9	399,0
14	Олон улсын байгууллагын албан хэрэгцээний бараа	64,7	77,7	16,1
15	Бусад	5 575,6	6 689,5	1 392,1
	Дүн	62 117,2	73 171,7	13 152,9

2.2 Гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөгдсөн барааны ашиглалтад тавих хяналт хангалтгүй байна.

УГЕГ-ын Бүрдүүлэлтийн дараахь шалгалтын хэлтэс УГЕГ-ын даргын 2006 оны 52 дугаар тушаалаар баталсан “Барааг гаалийн нутаг дэвсгэрт бүрмөсөн оруулах гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам”-ын 4.6-д заасан “Гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөгдсөн барааг бусдад худалдсан, шилжүүлсэн, өөр зориулалтаар ашигласан тохиолдолд гаалийн болон бусад албан татвар ногдуулж барагдуулна” гэж заасны дагуу аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага тооцох ёстой.

Ийм дутагдал илэрч байгаа бөгөөд татвараас чөлөөлөгдсөн бараа, машин, техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаархи мэдээлэл алга байна.


Дүгнэлт

Улсын гаалийн ерөнхий газрын зарим үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Гаалийн байгууллага зохих хуулийн дагуу гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөгдсөн бараа, машин, техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлээгүй, татвараас чөлөөлөгдсөн аж ахуйн нэгж, байгууллагад бүрэн хяналт тавьж чадахгүй байна.
- Импортын зарим барааны өртгийг бууруулж, иргэд, байгууллагад хямд үнээр худалдах зорилгоор импортын зарим бараа, материал, техник хэрэгслийг гааль болон НӨАТ-аас чөлөөлсөн боловч эдгээр барааг хэрэглэгчид худалдсан үнэ буурахгүй байна.
- Гаалийн мэдүүлэгт бараа материал импортлосон аж ахуйн нэгж, байгууллага, компаниуд хаяг, утас зэрэг мэдээллийг буруу мэдээлж байгаад хяналт тавьж чадахгүй байна.
- УГЕГ 2006 оны бараа, ажил, үйлчилгээг худалдан авах төлөвлөгөө боловсруулж мөрдөөгүй байна.
- Зарим гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.
- Хөрөнгө оруулалтын дансанд байгаа гүйцэтгэгч байгууллагын барьцаа хөрөнгийг тооцоо нийлж, өглөгийн дансанд тусгаж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Холбогдох байгууллагын санал

Улсын
гаалийн
ерөнхий
газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
210620 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их тойруу 81/1, Утас: 35-00-54, Факс: 35-00-60,
E-mail: gaali@customs.pmis.gov.mn;
http://www.customs.pmis.gov.mn

2007.06.26 № 02/2966
танай _____-ны № _____-Т

Тайлбар хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газраас Гаалийн ерөнхий газарт хийсэн шалгалтын дүнгийн тухай урьдчилан ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын газраас хийсэн шалгалтын хүрээнд манай байгууллагын ажилтай холбогдуулан өгч байгаа үнэлэлт, дүгнэлттэй санал нэг байна.

Аудитын тайланд тусгагдсан зарим асуудлаар дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан журам 2000 онд гарсан хэдий боловч 2006 онд тендерийн хууль шинэчлэгдэж, батлагдах хүртэл дээрхи журмыг хэрэгжүүлэх нарийвчилсан заавар 2007 оноос эхлэн мөрдөгдөж байгаа юм. Сангийн сайдын 2007 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 04 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тайлагнах журам”-ын Хоёрт заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг 2007 оноос эхлэн хийсэн бөгөөд харин 2006 оны худалдан авах ажиллаганы үр дүнгээр дээрх журмын гуравт заасны дагуу тайлан гаргасан.
- Худалдан авах ажиллагааны тухай шинэчлэгдсэн хуулийг 2006 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөж байгаа тул уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан журмыг баримтлан ажиллаж байна.
2. “Үүрэг трейд”ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 16 айлын орон сууцныг 2007.06.22-ны өдөр бүрэн хэмжээгээр хүлээн авч ажилтнууддаа хувиарлан өгсөн. Уг орон сууцныг 2007.03.10-нд ажил нь дуусч бэлэн болсон боловч Улсын комисс ажиллахгүй байсаар хугацаа хэтэрсэн нь гүйцэтгэгч, захиалагч байгууллагын буруутай үйл ажиллагаа биш юм.
3. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум дахь гаальчдын “Номт” амралтын газарт 2006 оны 4-р улиралд худаг гаргахаар гэрээ хийгдэж худаг өрөмдөх, насос угсрах ажлууд хийгдсэн боловч модон барилгын ажил, холбогдох холболтын ажлууд өвлийн улиралд

0901853

хийгдэх боломжгүй болсон тул хойшлуулж, санхүүжилтийг бүрэн олгоогүй юм. Шалгалтын явц дунд уг худгийн ажил бүрэн хэмжээгээр дуусч байнгын ашиглалтад оров.

4. УТЕГ-ын конторын өргөтгөлийн барилгын суурийн ажлыг хийх явцад инженерийн хийц бүхий дулааны шугам, цэвэр усны шугам, цахилгааны өндөр хүчдэлийн шугам, шилэн кабель, холбооны шугам орсныг холбогдох мэргэжлийн байгууллагуудын хүчээр зайлуулах ажил өвлийн улиралтай давхцсан тул гүйцэтгэгч байгууллагын ажилд нөлөөлсөн тал бий. 2007 оны дулааны улирал эхэлмэгц барилгын ажлыг жигдрүүлж, алдсан хугацааг нөхөх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж ашиглалтад орох хугацааг тохироод байна. 2007 оны 6 дугаар сарын 25-ны байдлаар барилгын ажил шинэчилсэн графикийн дагуу явагдаж байна.

5. Төрийн Өмчийн Хороо үндсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг олгохдоо тухайн барааны тоо хэмжээ, загвараас гадна худалдан авах босго үнийг тогтоон өгч байгаа нь зарим тохиолдолд зах зээлийн үнээс зөрөх, үнийн саналыг тендерт оролцогчид ирүүлдэг тул бага үнийн саналыг шалгаруулсан ч дээрх босго үнээс хэтрэх тохиолдол гарч байна.

Энэ байдлаас шалтгаалан дээрх босго үнийг нэмэх талаар ТӨХ-нд дахин хандаж, хүсэлт тавихад олон хоногоор удааширдаг, зөвшөөрдөггүйгээс тендерийг хүчингүй болгох, тендерийн хүчинтэй хугацааг сунгах, тендерт оролцогчдыг чирэгдүүлэх зэрэг бэрхшээлүүд байнга гарч байна. Иймд энэ талаар тодруулга, чиглэл авах зорилгоор Сангийн Яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газарт албан ёсоор хандахад 2006 оны 11 дүгээр сарын 14-ний 9-11/4813 тоотойр “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулиар Төрийн Өмчийн Хороонд тусгайлан үнийн хязгаар тавих эрх олгогдоогүй бөгөөд хуулийн 11.8-д заасны дагуу үндсэн хөрөнгө худалдан авах шаардлагатай эсэх талаар зөвшөөрөл олгодог. Мөн “Төсвийн тухай хууль”, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд заасан журмын дагуу, батлагдсан төсөвт өртөгт нь багтаан худалдан авч, санхүүжүүлэх тул ТӨХ нь босго үнийг тогтоох үндэслэл байхгүй гэсэн тайлбарыг ирүүлж байсан болно.



Н. ЧУЛУУНБААТАР

хийгдэх боломжгүй болсон тул хойшлуулж, санхүүжилтийг Шалгалтын явц дунд уг худгийн ажил бүрэн хэмжээгээр дуусч ба

4. УГЕГ-ын конторын өргөтгөлийн барилгын суури, инженерийн хийц бүхий дулааны шугам, цэвэр усны шугам, цахиурын шугам, шилэн кабель, холбооны шугам орсныг холбогдох мэргэжлийн хүчээр зайлуулах ажил өвлийн улиралтай давхцсан тул гүйцэтгэж нөлөөлсөн тал бий. 2007 оны дулааны улирал эхэлмэгц барилга алдсан хугацааг нөхөх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хугацааг тохироод байна. 2007 оны 6 дугаар сарын 25-ны бодлогоор шинэчилсэн графикийн дагуу явагдаж байна.

5. Төрийн Өмчийн Хороо үндсэн хөрөнгө худалдан авах тухайн барааны тоо хэмжээ, загвараас гадна худалдан авах босго үнэ нь зарим тохиолдолд зах зээлийн үнээс зөрөх, үнийн санал ирүүлдэг тул бага үнийн саналыг шалгаруулсан ч дээрх босго үнэ байна.

Энэ байдлаас шалтгаалан дээрх босго үнийг нэмэх талаар хүсэлт тавихад олон хоногоор удааширдаг, зөвшөөрдөггүйгээр болгох, тендерийн хүчинтэй хугацааг сунгах, тендерт оролцогч бэрхшээлүүд байнга гарч байна. Иймд энэ талаар тодруулга, Сангийн Яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулах хандахад 2006 оны 11 дүгээр сарын 14-ний 9-11/4813 тоотой нутгийн өмчийн тухай “ хуулиар Төрийн Өмчийн Хороонд тусгай зориулалтаар эрх олгогдоогүй бөгөөд хуулийн 11.8-д заасны дагуу үндсэн шаардлагатай эсэх талаар зөвшөөрөл олгодог. Мөн “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”, “Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу, батлагдсан төсөвт өртөгт нь багтаан худалдан авч, санхүүжүүлж үнийг тогтоох үндэслэл байхгүй гэсэн тайлбарыг ирүүлж байсан б



Н. ЧУЛУУ

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Сангийн сайд Н.Баяртсайханд:

- Аж ахуйн нэгж, байгууллагууд хууль, тогтоомжийн дагуу гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөгдсөн бараа, машин, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, эзэмшилт, үйл ажиллагааны талаар тайлан мэдээ гаргуулж, нэгтгэх, хяналт тавих асуудлыг журамлах

УГЕГ-ын дарга Б.Баттөмөрт:

- Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоол, Сангийн сайдыг 2007 оны 4 дүгээр тушаалын дагуу бараа, ажил, үйлчилгээний худалдан авах төлөвлөгөөг боловсруулж, батлуулж байх
- Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээнд заасан хугацаанд ашиглалтад оруулаагүй зарим гүйцэтгэгч байгууллагатай хариуцлага тооцох, гэрээний биелэлтийг хугацаанд нь дүгнэх, түүнд тавих хяналтыг сайжруулах
- Хөрөнгө оруулалтын дансанд байгаа гүйцэтгэгч байгууллагын барьцаа хөрөнгийн тооцоо нийлж, өглөгийн дансанд тусгаж үлдэгдлийг баталгаажуулах
- Монгол Улсын хуулийн дагуу гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн бараа материал, техник хэрэгслийн худалдсан үнийн түвшингийн талаар судалгааг хийж, мэдээлэх арга хэмжээ авах

Аудитын тайланг батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Улсын гаалийн ерөнхий газрын зарим үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Сангийн яам, Улсын гаалийн ерөнхий газарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2007 оны 10 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Улсын гаалийн ерөнхий газрын дарга Б.Баттөмөр нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л..ЖАВЗМАА